

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД**

2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр

Б.ЭНХБАЯР

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хороо, Эрүү шүүлтийн эсрэг хорооноос гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүхийн тогтолцоог бүрдүүлэх талаар судалж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Үүний дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1 дэх заалтад Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн 1 дэх заалтад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг тус тус байгуулахаар заасан.¹

Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд тус зохицуулалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.²

Түүнчлэн “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоолын 4-т нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн болон давж заалдах шатны шүүх байгуулсантай холбогдуулан эрүү, иргэний хэргийг хянан шийдвэрлэх хууль тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусган Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэхийг даалгасан болно.

1.2.Практик хэрэгцээ, шаардлага

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулах дараах практик хэрэгцээ, шаардлага үүсээд байна. Үүнд:

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721145671>

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721217671>

1/Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” Арван хоёрдугаар бүлгээр гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулж байна.

Гэвч уг бүлэг нь зөвхөн гэрлэлт цуцлуулах тухай болон түүнтэй холбоотой хүүхдийн асрамж, тэтгэлэг гаргуулах гэх мэт нэхэмжлэлийн үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах журмаас бүрддэг буюу бусад гэр бүлийн холбогдолтой хэргийн төрлийг хамруулаагүй бөгөөд гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцсэн зохицуулалт дутагдалтай байна.

Тухайлбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд “гэр бүлийн холбогдолтой хэрэг”, “гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан” гэх мэт өөр өөр нэр томъёог заасан байдаг төдийгүй зарим гэр бүлийн хэрэг болох хүүхдийн эцэг, эхийг тогтоох, эцэг, эх байх эрхийг хасах, хязгаарлах, сэргээх, хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох зэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэрэг гэж тодорхойлсон.

Олон улсын туршлагаас үзвэл, 1949 онд Япон Улсад байгуулагдсан гэр бүлийн хэргийн дагнасан шүүх нь Азийн хамгийн анхны гэр бүлийн хэргийн дагнасан шүүх болж байгуулагдаж байсан бөгөөд Personal Status Litigation Act буюу Гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх хуулиар гэр бүлийн хэрэгт тохирсон онцлог процесс ажиллагааг нь зохицуулдаг байна.³

Түүнчлэн Бүгд найрамдах Солонгос улс /БНСУ/-д 1963 онд Сөүл хотын гэр бүлийн хэргийн дагнасан шүүх байгуулагдсан нь Япон Улсын дараа орох анхны гэр бүлийн дагнасан шүүх болно. Тус шүүх нь Family Litigation Act буюу Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх бие даасан хуульд гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх онцлог зохицуулалтыг бий болгосон.

Ийнхүү гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог зохицуулалтыг гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх бие даасан хуульд тусгасан байх ба уг хуульд зохицуулаагүй харилцааг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх процессын хуулиар зохицуулдаг байдал нийтлэг ажиглагдаж байна.⁴

Дээрх улсуудын гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиудад “гэр бүлийн хэрэг” гэдэгт гэрлэлт цуцлалт, түүнтэй холбоотой хүүхдийн тэтгэлэг гаргуулах, хүүхдийн асрамжийг хэнд үлдээх, дундын эд хөрөнгийг хуваах зэрэг хэргээс гадна үрчлэлт, асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоох, хүчингүй болгох, хүүхдийн эцэг, эхийг тогтоох, гэрлэлт хүчин төгөлдөр бусад тооцох, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бусад тооцох зэрэг олон төрлийн хэргийг хамруулдаг байна.⁵

Мөн БНСУ-ын хувьд litigious cases буюу мэтгэлцээн бүхий, non-litigious cases буюу мэтгэлцээнгүй хэрэг гэж нийт харьяаллын хэргийг 2 ангилж, 5 дэд хэсэг (А-Е)-т хувааж жагсаасан. Өөрөөр хэлбэл, мэтгэлцээнтэй хэрэг, мэтгэлцээнгүй хэрэгт ялгамжтай процессын журам хэрэглэгддэг бөгөөд мэтгэлцээнтэй хэрэгт иргэний процессын хуулийн зохицуулалт, мэтгэлцээнгүй хэргийг Non-Contentious Case Procedure Act буюу Мэтгэлцээнгүй хэргийг шийдвэрлэх процессын хуулийг хэрэглэдэг байна.

³ <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4178/en>

⁴ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=1081&lang=ENG

⁵ Personal Status Litigation Act Japan 2003, 2 дугаар зүйл. Family Litigation Act 2007, 2 дугаар зүйл.

В, С, Е ангиллын хэргүүд нь conciliation-precondition principle зарчим хэрэгждэг буюу эвлэрүүлэн зуучлалаар заавал орох гэрлэлт цуцлалт, түүнтэй холбоотой хүүхдийн асрамж, тэтгэлэг, дундын эд хөрөнгө хуваах, хамтын амьдрал байсан эсэхийг тогтоох, гэрлэлт цуцлалтын улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг хэргүүд болно.

Харин А, D ангиллын хэрэг болох гэрлэлт, гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцох, сураггүй алга болсонд тооцох, сураггүй алга болсонд тооцсоныг хүчингүйд тооцох, овог нэр тогтоох, үрчлэлт, асран хамгаалалт, харгалзан дэмжлэг, гэрлэлтийн гэрээнд өөрчлөлт оруулах, өв гэрээслэл зэрэг нь эвлэрүүлэн зуучлал шаардлагагүй буюу эвлэрүүлэн зуучлалын бус хэрэг байдаг.

Иймд хуулийн төслөөр “гэр бүлийн хэрэг”-ийн төрлийг өргөжүүлж, ердийн журмаар, онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хэрэг болгон ангилан, тэдгээрийн онцлогт нь тохирсон процессыг боловсронгуй болгох шаардлагатай үүссэн болно.

2/Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд диспозитив зарчмаас гадна хүүхдийн хууль ёсны дээд эрх, ашиг сонирхол /best interest of the child/-ыг тэргүүн ээлжид хамгаалах зорилгоор гэр бүлийн нөхцөл байдлыг нарийн шалган тогтоох /fact finding/ ажиллагаа хийгддэг. Энэ нь шүүхийн ex officio оролцоогоор илэрдэг.

Энэхүү шүүхийн ex officio оролцоогоор шүүх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд буюу хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах үүднээс холбогдох байгууллагаас лавлагаа, тодорхойлолт, мэдээлэл гаргуулах идэвхтэй байдлыг шаарддагаараа ердийн иргэний хэргийн шүүхээс ялгаатай.

Мөн гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч шүүхийн ажилтан байх, энэхүү шинжээчийн үнэлгээний тайлангийн талаар процессыг тодорхой болгох шаардлагатай байна.

Тухайлбал, Япон, БНСУ зэрэг гэр бүлийн дагнасан шүүхтэй улсуудад, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүгч өөрийн санаачилгаар захирамж гарган гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч /family investigator/-ээр гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлуулж, үнэлгээний тайлан гаргуулах, ач холбогдол бүхий бусад шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах зэрэг бүрэн эрхтэй байдаг.

Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч гэр бүлийн нөхцөл байдлыг нягтлан шалгаж, маргааны шалтгаан нөхцөлийг тогтоож, эвлэрэх боломжтой эсэх, боломжтой бол эвлэрэх арга замыг санал болгох, хүүхдээс асрамжийн асуудлаар санал авахаар хүүхэдтэй ярилцлага хийх зэргээр шүүгч шийдвэрээ гаргахад шаардлагатай нөхцөл байдлыг тал талаас нь судална.

Энэхүү гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч нь шүүхийн ажилтан байх бөгөөд аль ч талд орохгүй, хараат бусаар, асуудлыг тал бүрээс нь судлах үүрэгтэй

бөгөөд хуульч бус, нийгмийн ухаан, сэтгэл зүй, боловсрол зэрэг чиглэлийн магистрын зэрэгтэй байх шаардлага тавигддаг.⁶

БНСУ-ын хувьд, А, В ангиллын хэрэгт буюу гэрлэлт цуцлалт, гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бусад тооцох, үрчлэлт зэрэг зарим хэрэгт гэр бүлийн шүүхийн шүүгч шинжлэн судлах ажиллагаа /ex officio fact finding/ явуулдаг буюу гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судалсан үнэлгээг шийдвэр гаргахдаа харгалзан үздэг.⁷

Манай улсын хувьд энэ талаарх зохицуулалт хуульд байхгүй ч Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан нөхцөл байдлын үнэлгээг хийлгэж, гэрлэлт цуцлахад нотлох баримтаар авч үзэж байгаа практик байна.

Хуулийн төслөөр шүүгч тодорхой хэрэгт, тухайлбал хүүхдийн дээд эрх, ашиг сонирхолыг хангах үүднээс гэрлэлт цуцлахад хүүхдийг хэний асрамжид үлдээх асуудлыг шийдвэрлэхэд зөвхөн талуудын нотлох баримтад тулгуурлах бус өөрийн санаачилгаар гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлах /fact finding/ ажиллагаа явуулах процесс, системийг бий болгох шаардлагатай байна.

3/Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн шатанд шүүх талуудыг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авах боловч эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрхэн хийх процесс, систем байхгүй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 129 дүгээр зүйлийн 129.1.7 дахь заалтад “Шүүгч шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэхдээ зохигчид эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрэх хугацаа заах арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргаж болно” гэж, мөн хуулийн 132 дугаар зүйлийн 132.5 дахь хэсэгт “Гэрлэгчид шүүхээс эвлэрүүлэх арга хэмжээ авсан хугацаанд эвлэрээгүй бол шүүгч гэрлэлтийг цуцлах шийдвэр гаргана.” гэж зааснаас харахад заавал шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд орох, ингэж орох зорилго нь цуцлуулах нэхэмжлэлтэй гэрлэгчдийг гэрлэлтээ цуцлуулахгүй байх буюу бодит утгаараа эвлэрүүлэхэд чиглэж байна.

Ингэснээр гэрлэлт цуцлалтын тохиролцоог талууд эвлэрүүлэн зуучлалын үе шатанд хийлгүйгээр эвлэрүүлэн зуучлалын хугацаа өнгөрөх, шүүх урьдчилсан арга хэмжээний дараа шилжиж ирсэн гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэж, гэрлэлтийг цуцалж байна.

Иймд шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эвлэрүүлэн зуучлах ажиллагааг тодорхой тохиолдолд явуулах /гэр бүлийг аврах, боломжгүй тохиолдолд маргаантай асуудлаар эвийн тохиролцоо хийлгэх/ систем, процессыг бий болгоно.

4/Эвлэрүүлэн зуучлалаар заавал урьдчилан орох гэр бүлийн хэргээс заавал эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар урьдчилан орохгүй байх онцгой тохиолдуудыг бий болгоно.

⁶ IDLO зөвлөх Hyoung-ryul, KIMPresiding Judge, Seoul Family Court-ийн хуулийн төсөл боловсруулахад өгсөн зөвлөмж 2025.

⁷ IDLO зөвлөх Hyoung-ryul, KIMPresiding Judge, Seoul Family Court-ийн хуулийн төсөл боловсруулахад өгсөн зөвлөмж 2025.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн шинэчилсэн мэдээллээр, 2021 онд 45,444 иргэний хэрэг шийдвэрлэснээс Гэр бүлийн тухай хуулиар 4690 буюу нийт иргэний хэргийн 10.3 хувийг, 2022 онд нийт шийдвэрлэгдсэн 57,633 иргэний хэргийн 6263 буюу 10.8 хувийг, 2023 онд шийдвэрлэгдсэн нийт 63,407 иргэний хэргийн 5913 буюу 9.3 хувийг, 2024 онд нийт шийдвэрлэгдсэн 73727 иргэний хэргийн 6520 буюу 9 хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван хоёрдугаар бүлэг “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны дагуу шийдвэрлэсэн иргэний хэрэг тус тус эзэлж байна.

Өөрөөр хэлбэл, Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэгдсэн иргэний хэргийн 4 жилийн дундаж нийт иргэний хэргийн 9.8 хувь байна.

Монгол Улсын хэмжээнд 2022 онд 17694, 2023 онд 17596, 2024 онд 14165 гэрлэлт бүртгэгдсэн байна. Мөн 2022 онд 4515, 2023 онд 4825, 2024 онд 4459 гэрлэлт дуусгавар болсон байна.

Өөрөөр хэлбэл, гэрлэлт дуусгавар болсон тохиолдлын гэрлэлт бүртгэлд харгалзах хувь 2022 онд 25.5 хувь, 2023 онд 27.4 хувь, 2024 онд 31.4 хувь буюу гэрлэлт дуусгавар болох нь жил ирэх тусам нэмэгдэж байна.

Гэрлэлт цуцлах хэргийн тухайд, 2020 онд 3015 хэргийг эвлэрүүлэн зуучлалд шилжүүлснээс 88 хувьд нь амжилтгүй буюу 353-т нь буюу 12 хувьд нь л амжилттай эвлэрсэн буюу гэрлэлт цуцлуулахаа болихоор шийдсэн байна. 2021 онд 3861 гэрлэлт цуцлах хэргийг эвлэрүүлэн зуучлалд шилжүүлснээс 88 хувьд нь амжилтгүй эвлэрээгүй буюу гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлуулахаар болсон буюу дийлэнх тохиолдолд шүүхийн өмнөх шатны эвлэрүүлэн зуучлал амжилтгүй болж байна.

Монгол Улсын 2024 оны шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээнд гэрлэлт цуцлах 3826 маргааныг эвлэрүүлэн зуучлалд шилжүүлснээс 12.3 хувь нь амжилтай, 87.7 хувь нь амжилтгүй болсон.

Нөгөөтэйгүүр, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсэгт зааснаар Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүгч эвлэрүүлэх арга хэмжээг авалгүйгээр гэрлэлтийг цуцалж болох ганц тохиолдол байдаг.

Энэхүү тохиолдлын хувьд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг хүлээн авахдаа аливаа шаардлага, цензур, холбогдох нотлох баримтыг шаардаж шалтаг заан буцаахгүй байхад анхаарах хэрэгтэй байгааг судлаачид онцолжээ.⁸

Хүчирхийлэл үйлдэгдсээр байтал нотлохыг шаардаж, гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг хүлээж авахгүй байх талаарх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсэг, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг нь хүүхдийн болон гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөөг хязгаарласан зохицуулалт болсон.

⁸ Б.Дугармаа, Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2019 он, №4, 112 дахь тал.

Иймд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй бол заавал нотлох баримт шаардахгүйгээр хүсэлтийг авч, эвлэрүүлэн зуучлалаар орохыг шаардахгүй болгоно.

Мөн гэр бүлийн хүчирхийллээс гадна, тухайлбал тусдаа амьдраад тодорхой хугацаа өнгөрсөн, бага насны хүүхэдгүй, эсхүл өөр хүнээс хүүхэдтэй бөгөөд тусдаа амьдарч байгаа, гэрлэлт цуцлах шийдвэрийг гэрлэгчдийн аль аль нь хүлээн зөвшөөрсөн, эсхүл эд хөрөнгийн маргаантай ч хүүхэдгүй, гэрлэлт цуцлалтаа харилцан хүлээн зөвшөөрсөн /Гэр бүлийн тухай хуулийн 13.1-д зааснаар эд хөрөнгийн маргаангүй, хүүхэдгүй гэрлэгч гэрлэлт цуцлалтаа хүлээн зөвшөөрсөн бол захиргааны журмаар цуцалдаг боловч энэ тохиолдолд гэрлэгчид эд хөрөнгийн маргаантай тул шүүхийн журмаар цуцлах тохиолдолд хамаардаг./ тохиолдолд шүүхийн өмнөх урьдчилсан арга хэмжээ болох эвлэрүүлэн зуучлалаар заавал орохгүй байх онцлог тохиолдол /exception/-ыг бий болгоно.

Учир нь 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 21 шүүхийн эвлэрүүлэн зуучлалын нэгжээс ирүүлсэн мэдээллийг нэгтгэхэд нийт **8,035** өргөдөл хүлээн авснаас **3,352** буюу **41.7%** нь гэр бүлийн маргаан байна. Үүнээс 1339 нь тусдаа амьдраад тодорхой хугацаа өнгөрсөн гэрлэгчид байна.

Гэр бүлийн маргааны ангилал (Тусдаа амьдарсан хугацаагаар):

Судалгаанд хамрагдсан нийт гэр бүлийн маргааны дотроос тусдаа амьдарсан хугацааг тодорхой дурдсан 1,339 тохиолдлыг авч үзвэл:

Тусдаа амьдарсан хугацаа	Маргааны тоо	Эзлэх хувь
3 хүртэл жил тусдаа амьдарсан	585	43.7%
3-5 жил тусдаа амьдарсан	338	25.2%
5-аас дээш жил тусдаа амьдарсан	416	31.1%
<u>НИЙТ</u>	<u>1,339</u>	<u>100%</u>

Гэрлэлтээ цуцлуулахаар хандаж буй тохиолдлуудын **31.1%** нь 5-аас дээш жил, **25.2%** нь 3-5 жил тусдаа амьдарсан байна. Энэ нь нийт 1339 тохиолдлын талаас илүү хувь (**56.3%**) нь 3-аас дээш жил хамтран амьдраагүй бөгөөд эргэн нийлэх боломжгүй болсон байдгийг харуулж байна.

Удаан хугацаагаар тусдаа амьдарсан маргаан эвлэрүүлэн зуучлалаар амжилтгүй болж шүүхэд шилжсэний дараа эргэн эвлэрсэн тохиолдол маш цөөн буюу нийт **7** байна. Энэ нь талууд эргэлт буцалтгүй шийдвэр гаргасан үедээ шүүх, эвлэрүүлэн зуучлалд ханддагийг нотолж байгаа талаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Эвлэрүүлэн зуучлалын зөвлөлөөс ирүүлсэн мэдээлэл дурджээ.

Үүнээс гадна гэрлэлтээ цуцлуулахаар харилцан тохиролцсон, 18-аас доош насны хүүхэдгүй, зөвхөн эд хөрөнгийн маргаантай тохиолдол нийт **55** бүртгэгдсэн нь энэ төрлийн маргаан цөөн, иймд эдгээр тохиолдолд эвлэрүүлэх арга хэмжээ авахгүй байх зохицуулалт нь бодит байдалд нийцэж байна гэжээ.

Иймээс эргэлт буцалтгүй шийдвэр гаргасан тусдаа амьдраад тодорхой хугацаа өнгөрсөн, эсхүл эд хөрөнгийн маргаантай боловч цуцлах талаар шийдвэрт хүрсэн, хүүхэдгүй гэрлэгчдийн хувьд эвлэрүүлэн зуучлалаар заавал орохгүй байхаар тусгаж, шүүхийн үйлчилгээг шуурхай авах иргэдийн эрхийг хангаж, эвлэрүүлэн зуучлалыг аврах боломжтой үлдсэн тохиолдлууддаа чанартай хүргэх зорилгыг дэмжиж ачааллыг нь бууруулах шаардлага үүсчээ.

Мөн Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн анхан шатны тойргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэхээр харьяалуулах эрүү, зөрчлийн хэргийн харьяаллыг тогтоох, өсвөр насны хүний үйлдсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүүхдийн ашиг сонирхлыг хангах хүрээнд боловсронгуй болгох шаардлага үүссэн болно.

2022 онд нийт 208, 2023 онд нийт 222, 2024 онд нийт 171 өсвөр насны хүн эрүүгийн хэрэгт ял шийтгүүлсэн байна. 2024 онд өсвөр насны 70 хүн хорих ял авч, 39 өсвөр насны хүний тогтоол биелүүлэхийг хойшлуулж, 132 өсвөр насны хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэжээ.

Өсвөр насны хүний цагдан хоригдох, баривчлах боломжийг бууруулж, аль болох батлан даагчийн хяналтад өгөх, хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд сургууль дээр нь баривчлахгүй байх, мэдүүлэг авахад сэтгэлзүйч, сурган хүмүүжүүлэгчийн оролцоо байх, асуултыг бүрэн ойлгосон эсэхэд эргэлзээ төрвөл мөрдөгчийн зөвшөөрлөөр тодруулах, хэргийг боломжтой бол нэгтгэх зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэдгээрийн эрхийг хангах шаардлага үүссэн.

Түүнчлэн гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл гаргахад тухайн нэхэмжлэгч гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй нөхцөлд байвал түүнтэй холбоотой зөрчил, эрүүгийн хэргийг эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэж байгаа бол тухайн эрүү, зөрчлийн хэргийг мөн энэхүү гэр бүл, хүүхдийн дагнасан шүүх харьяалан нэг дор шийдвэрлэж, гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл гаргаснаараа гэр бүлийн хүчирхийллийн улам том хохирол амсахаас сэргийлэх зохицуулалт шаардлагатай болсон.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслөөр гэр бүлийн хэргийг нэхэмжлэл, хүсэлтээр үүсгэж, шүүхээс хянан шийдвэрлэх, шүүхийн шатанд зарим гэр бүлийн хэрэгт эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг зохицуулах бөгөөд дараах байдлаар хуулийн төсөлд холбогдох асуудлыг тусгана. Үүнд:

-Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилт, холбогдох хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн зарчмын талаар тусгах бөгөөд эдгээр зохицуулалтын гол зорилго нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд авч үзэж, хамгаалахад чиглэнэ;

-Хоёрдугаар бүлэгт гэр бүлийн хэрэг, шүүхийн харьяалал, нэхэмжлэл, хүсэлт гаргах шүүхийн харьяалал, зохигч өөрөө шүүх хуралдаанд оролцох журам, шүүх хуралдаан хаалттай явуулах, шүүгч хэргийг дангаар шийдвэрлэх асуудлыг тусгана;

-Гуравдугаар бүлэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заагаагүй гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх онцлог зохицуулалтыг тусгана;

-Дөрөвдүгээр бүлэгт шүүхийн шатанд зарим гэр бүлийн хэрэгт эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах зохицуулалтыг тусгана;

-Тавдугаар бүлэгт бусад хэсэг буюу хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтыг тус тус тусгана.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дүнд хүрнэ гэж үзэж байна:

- Гэр бүлийн хэргийг хүүхдийн эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах буюу гэрлэлт цуцлалт, эцэг, эх байх эрх хасах, хязгаарлахад хүүхэд хохирохгүй байх;

- Гэрлэлт цуцлалт болон холбогдох бусад гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэхэд хүүхэдтэй холбогдолтой асуудлыг нэхэмжлэл гаргасан эсэхээс үл хамаарч заавал шинжлэн судалж, шийддэг байх;

- Тодорхой тохиолдолд шүүхийн өмнөх урьдчилсан арга хэмжээ болох эвлэрүүлэн зуучлалд заавал хандахгүй байх тохиолдол бий болсноор зөвхөн эвлэрэх боломжтой хэрэгт тус эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдах нөхцөл бүрдэнэ;

- Шүүхийн шатанд шүүгч шаардлагатай гэж үзвэл эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах процесс бий болно;

-Шүүхийн өөрийн санаачилгаар нөхцөл байдлыг тал бүрээс шинжлэн судлах үүрэг оролцоо нэмэгдсэнээр хүүхдийн тэргүүн дээд эрх ашиг сонирхол хангагдана;

-Шүүх хуралдаанд зохигч танхимаар болон цахим хэлбэрээр өөрөө оролцох, хилийн чанадад байгаа зохигч цахимаар оролцох боломж бий болно;

- Шүүгч, эвлэрүүлэн зуучлагч нар гэр бүлийн эрх зүйгээр мэргэших, гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн систем шүүхэд бий болох, цаашлаад эцэг, эхийн хүүхдийн өмнө хүлээх гэр бүлийн хариуцлага дээшлэх зэрэг эерэг үр дагавар бий болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн анхан шатны шүүхэд өсвөр насны хүний үйлдсэн эрүү, зөрчлийн хэргийг шийдвэрлэх, зөрчил байхаас нь ухааруулж, цаашид гэмт хэрэг үйлдэхээс нь сэргийлэх, хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох процессыг боловсронгуй болж, хүүхдийн эрх хангагдана.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг

хэрэгжүүлэхтэй шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн талаар

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээтэй нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай тус тус хуулийн төсөл болон Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулна.

—000—